



**ДУНГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 246

Мандалговь

Орон сууцны хувьчлах тухай


Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Монгол улсын Орон сууц хувьчлах тухай хуулийн 16 дугаар зүйлийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Цагдаагийн хэлтсийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 8'500'700 /найман сая таван зуун мянга долоон зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, 1'239'685 /нэг сая хоёр зуун гучин ес зургаан зуун нэг тн тав/ төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 4 айлын орон сууцны барилгыг хавсралтын дагуу метр квадрат бүрийн үнийг 72 000 /арван таван мянга/ төгрөгөөр эзэмшигч тус бүрт нь худалдаж, хувьчлахыг зөвшөөрсүгэй.

2. Орон сууцны худалдах үнийг одоогийн эзэмшигчдээс 2014 оны 4-р улиралд багтаан 100 хувь гаргуулж, Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг, мөн худалдсан орон сууцны барилгыг хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга Л.Гүндсүрэнд даалгасугай.

3. Тогтоосон хугацаанд төлбөр нь хийгдээгүй байрыг дуудлага худалдаагаар худалдахыг Орон нутгийн өмчийн алба /П. Очирбат/-д даалгасугай.

ДАРГА  С. БУДЖАВ



Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 10 сарын
06 өдрийн 116-р тогтоолын хавсралт

Хувьчлах орон сууц

№	Одоо оршин сууж буй төрийн албан хаагч	Эрхэлж буй албан тушаал	Эзэмшсэн жил	Талбай /м ² /	Худалдх үнэ
1	Б.Энхжаргал	Холбооны инженер	3	46,9	3'376'800
2	Ж.Батаа	Жолооч	7	46,9	3'376'800
Нийт дүн					6'753'600